ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

**БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**

**ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 30 өдөр    Дугаар А/132    Бат-Өлзий сум

"Эрүүл сүрэгтэн" батламж олгох туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх тухай.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт,, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4, 14.6, 14.7, Мал эмнэлгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн А/21 дүгээр тушаал, Хүнс, хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар батлагдсан "Халдварт өвчингүй, тайван байдлыг улс, бүс, нутгаар тогтоон мэдээлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бруцеллёз өвчнөөс үхэр сүргийг эрүүл болгон баталгаажуулах ажлын хэсгийг бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус батлаасугай.

2 Бруцеллёз өвчнөөс эрүүлийг баталгаажуулах ажлын мэдээллийг малчдад хүргэн, шинжилгээнд хамрагдах өрхийн судалгааг гаргаж, үхэр сүргийг бэлэн байлгах ажлыг зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт, товлосон хугацаанд уг арга хэмжээнд үхэр сүргээ бүрэн хамруулахыг мал бүхий иргэд, малчдад тус тус үүрэг болгосугай.

3. Шинжилгээнд дээж авч, шинжлэх ажлыг стандартын дагуу зохион байгуулахыг "Хутагт уулын өгөөж" Мал амнэлгийн үржлийн нэгжийн эмч (П.Содномбалжир, С.Цэнд-Аюуш) нарт, хяналт тавьж ажиллахын Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (П.Аюушжав) –д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА    С.АМГАЛАН

My Doc Zakhiramj /ZD/ 2023

622301265

Бат-Өлзий сумын Засаг даргын
2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн
А/132..захирамжийн ..1..дугаар хавсралт

# “ЭРҮҮЛ СҮРЭГТЭН” БАТЛАМЖ ОЛГОХ ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Хяналтын баг:

1.Н.Орхонтуул (Засаг даргын орлогч, Сумын нийтийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн дарга)

2.П. Аюушжав (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)

2. Шинжилгээний баг:

1. П.Содномбалжир (“Хутагт уулын өгөөж” мал эмнэлэг)

2.С.Цэнд-Аюуш (“Хутагт уулын өгөөж” мал эмнэлэг)

3. Мэдээлэл сургалт сургалт сурталчилгааны баг

1. Э.Бадамханд (Хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн)
2. Ж.Булганзаяа (Эрүүл мэндийн төвийн дарга)
3. 3. Д.Бямбасүрэн (2 дугаар багийн Засаг дарга)
4. 4. С.Төмөр (3 багийн дугаар Засаг дарга)
5. 5. Г.Пүрэвтогтох (4 дүгээр багийн Засаг дарга)
6. 6. Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Бат-Өлзий сумын Засаг даргын
2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн
А/132..захирамжийн 2.....дугаар хавсралт

## МАЛЫН ГАРАЛТАЙ БҮТЭЭГДЭХҮҮНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЗАМААР МАЛЧИН ӨРХӨД “ЭРҮҮЛ СҮРЭГТЭН” ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ТУРШИЛТЫН ХӨТӨЛБӨР АЖЛЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Сонгогдсон малчин өрхийн мал сүрэгт бруцеллёзын шинжилгээ хийх, шимэгч илрүүлэх, мах сүүнд антибиотикийн үлдэгдэл тодорхойлох замаар “Эрүүл сүрэгтэн” гэрчилгээ олгох туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлж сумын түвшинд хүнсний аюулгүй байдлыг баталгаажуулах загвар бий болгох

**Төсөл хэрэгжих сум:**Бат-Өлзий

| Бүтээгдэхүүн ба үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцан эзэн | Хамтран хэрэгжүүлэх хийх |
|---|---|---|---|
| **Бүтээгдэхүүн-1: Ажлын ерөнхий төлөвлөгөө болон хувийн мал эмнэлгүүдийн дээж цуглуулах, лабораторийн шинжилгээний нарийвчилсан төлөвлөгөө боловсруулагдсан байна:** | | | |
| Сумын Засаг даргын захирамж гаргуулж, сумын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж, хөрөнгө санхүүг шийдвэрлэх | 7-р сарын 01-ний дотор | Сумдын ЗДТГ, МЭТасаг | МЭҮНэгж |
| Тандалтад хамрагдах малын тоо, өрхийн судалгааг нарийвчлан гаргах | 6-р сарын 20-ний дотор | П.Аюушжав | ЗДТГазар, МЭҮНэгж |
| Тандалтын ажилд оролцох хүн хүч, хэрэглэгдэхүүн, зардлын тооцоог гаргах | 6-р сарын 10-ны дотор | П.Аюушжав | МЭХЦХЦэг, МЭҮНэгж |
| Сумын түвшинд хийгдэж байгаа бруцеллёзын тандалт шинжилгээний ажлыг зохион байгуулах, зорилтот өрхийг 100% хамруулах, сумын зохион байгуулалтад хяналт тавих | 7,8,9 сард | П.Аюушжав | МЭҮНэгж, МЭХЦХЦэг |
| **Бүтээгдэхүүн-2: Хувийн мал эмнэлгүүдэд дээж цуглуулах, лабораторид хийгдэх шинжилгээний арга зүй, шинжилгээний үр дүнг хэрхэн баталгаажуулах талаар сургалт явуулсан байна** | | | |
| Аймгийн мал эмнэлгийн газраас хувийн мал эмнэлгүүдэд дээж цуглуулах, лабораторийн шинжилгээ хийх талаар онол практикийн сургалт хийх | 7-р сарын 03-ны өдөр | Х.Мөнхцэцэг /Ажлын хэсэг/ | Сумдын МЭТасаг, МЭҮНэгж |
| МАА-н ЭЗЭН төслөөс тандалтанд хэрэглэгдэх багаж тоног төхөөрөмжийг хүлээн авч, сумдын МЭҮНэгжүүдэд хүлээлгэн өгөх | 7-р сарын 25-ны дотор | МАА-н ЭЗЭН | МЭГазар, МЭТасаг, МЭҮНэгж |
| “Эрүүл сүрэгтэн” батламж олгох туршилтын хөтөлбөрийн хүрээнд 30 малчинтай МЭҮНэгж гэрээ хийх. | 7-р сард | МЭҮНэгж | МЭТасаг |
| **Бүтээгдэхүүн-3: Лабораторийн шинжилгээгээр эрүүл гарсан өрхүүдэд “Эрүүл сүрэгтэн” гэрчилгээ олгосон байна** | | | |

| | | | |
|---|---|---|---|
| Засаг даргын Тамгын газар болон малчдад туршилтын хөтөлбөрийн зорилгыг танилцуулах | 7-р сарын 03-ны дотор | МЭГазар | МЭТасаг |
| Дээж цуглуулах цэгийг тодорхойлж, зураглал гаргах | 6-р сарын 26-нд | П.Аюушжав | МЭҮНэгж |
| Сумдын МЭТасаг, МЭҮНэгжүүд сумын зорилтот өрхөөс сүүний дээж цуглуулж, сүүний дээжинд шинжилгээ хийх /3 удаа/ | 7,8,9 сарын 10-ны дотор | МЭҮНэгж | МЭТасаг |
| Сүүний цагирган урвалаар эерэг гарсан өрхийн үхэр сүргээс ийлдсийн дээж цуглуулах | 7,8,9 дүгээр сарын 10-ны дотор | МЭТ, МЭҮНэгж | МЭГазар |
| Сүүний цагирган урвалаар сөрөг гарсан өрхийн үхэр сүргийг ийлдсийн дээж авч, баталгаажуулах шинжилгээ хийх /түүвэрчилж/ | 7,8,9 дүгээр сарын 10-ны дотор | МЭТ, МЭҮНэгж | МЭГазар |
| Туршилтын хөтөлбөрт оролцсон малчин тус бүрийн шимэгч өвчний нөхцөл байдлыг тодорхойлох | 7,8,9 дүгээр сарын 10-ны дотор | МЭҮНэгж | МЭТасаг |
| Дээж авсан цэг тус бүрийн малчин болон малын мэдээллийг бүртгэх, системд оруулах | 7,8,9 дүгээр сарын 10-ны дотор | МЭТ, МЭҮНэгж | МЭГазар |
| Сүүний шинжилгээгээр Эерэг, сөрөг гарсан өрхийн үхрийн ийлдсийн дээжинд аймаг РБУрвал, Улсад ELISSA, ХХУ, НТУрвалаар баталгаажуулах шинжилгээ хийх | 7,8,9-р сарын 10-ны дотор | Х.Мөнхцэцэг, МЭҮНэгж | Лабораторийн эмч нар, УМЭАЦТЛаборатори, МЭХүрээлэн |
| Сүүний цагирган урвалын 3 удаагийн шинжилгээгээр эрүүл болох нь батлагдсан малчин өрхүүдэд "Эрүүл сүрэгтэн" гэрчилгээ олгох | 9-р сарын 30-ны дотор | А.Энхтүвшин Х.Мөнхцэцэг | МЭТасаг |
| **Бүтээгдэхүүн 4: Мал сүрэг нь шинжилгээгээр эерэг гарсан малчин өрхийн гишүүдийг бруцеллёзын шинжилгээнд хамруулсан байна** | | | |
| Мал сүрэг нь бруцеллёзоор халдвартай гарсан малчдад мэдээлэл хүргэх | Тухай бүр | Сумдын МЭТасаг, ЭМТөв | МЭҮНэгж |
| Малчдыг бруцеллёзын шинжилгээнд хамруулах | 7-р сарын 25-наас 9-р сарын 01-ны хооронд | ЭМТөв | ЗДТГазар, МЭТасаг |
| Шинжилгээний үр дүнг тайлагнах | 9-р сарын 20 -ны дотор | ЭМТөв | ЗДТГазар, МЭТасаг |
| **Бүтээгдэхүүн 5: Малаас хүнд халдварладаг өвчнөөс сэргийлэх, хүнсний аюулгүй байдлыг хангахад малчдыг үүрэг оролцооны талаар сургалт зохион байгуулсан байна** | | | |
| Шинжилгээний хариуг малчдад, МЭТасаг, МЭТНэгжүүдээр дамжуулан цахим болон утсан холбоогоор эргэн мэдээлэх | Тухай бүр | МЭТасаг | МЭҮНэгж |
| Бруцеллёз өвчин нь малаас хүнд халддаг тухай мэдээлэл бүхий гарын | Тандалтын | МЭТасаг | МЭҮНэгж |

| | | | |
|---|---|---|---|
| авлага, зохистой дадал хэвшүүлэх гарын авлагыг малчдад тараах | хугацаанд | | |
| Сүүний цагираган урвалаар эерэг гарсан малтай айлуудын малчдад хөдөө аж ахуйн сайн дадлын сургалтыг сум бүр 2 удаа зохион байгуулах | Тандалтын хуагцаанд | МЭТасаг | МЭГазар |
| Тандалт шинжилгээ болон хийгдсэн ажлын мэдээллийн олон нийтийн сүлжээ болон сумын веб сайтад мэдээлэх, сурталчилах | Жилдээ | МЭГазар | МЭТасаг |
| **Бүтээгдэхүүн 6: Үр дүн, олж илрүүлсэн зүйлс, дүгнэлт, зөвлөмж бүхий тайлан боловсруулсан байна** | | | |
| Сумдын МЭТасгууд тандалт шинжилгээний явцын мэдээ болон эхний тайланг төсөлд хүргүүлэх. | 7-р сарын 10-ны дотор | МЭТасаг | МЭҮНэгж |
| Шинжилгээний үр дүнг багтаасан дэлгэрэнгүй тайлан бичих, Энэхүү тайланг санхүүгийн тайлангийн хамт МААЭЗЭНТ-д хүлээлгэн өгөх | 9-р сарын 30-ны дотор | Х.Мөнхцэцэг | Ажлын хэсэг |
| Нэгдсэн дүгнэлт гаргах, семинар зохион байгуулах. | 10-р сарын 10-ны дотор | МАА-н ЭЗЭН төсөл, МЭЕГазар | МЭГазар, МЭТ |

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

МАЛ ЭМНЭЛГИЙН ТАСГИЙН ДАРГА П.АЮУШЖАВ.

ХТУ9856 ТБАГУТҮГ 3565351